



The Asia Foundation



2019

**АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН
ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА**

Canada 



The Asia Foundation



Sant-Maral Foundation

Энэхүү судалгааг Канадын Засгийн газар, Канадын гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр хийсэн болно. Судалгааг Азийн Сан, Сант Марал сантай хамтран явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Канадын Засгийн газар болон Канадын Гадаад хэргийн яамны үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

Хавтасны зургийг Гэрэл зурагчин Г.Батсайхан

АВЛИГЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ ТОГТООХ СУДАЛГАА

АРДЧИЛСАН ОРОЛЦООТОЙГООР ТӨРИЙН АЛБАНД САЙН
ЗАСАГЛАЛ, ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ (STEPS)

Улаанбаатар
2019

АГУУЛГА

Зураг болон Хүснэгтийн жагсаалт	III
Судалгааны гол үр дүн	V
Өмнөх үг	VI
1. Судалгааны тухай	1
2. Өгөгдөл цуглуулах	5
3. Авлигын өөрчлөлт.....	9
4. Авлигын эсрэг тэмцлийг хэн удирдан чиглүүлэх ёстой вэ?	15
5. Засгийн газрын үүрэг	21
6. Байгууллагууд	29
7. Мэдээллийн сувгууд.....	33
8. Олон нийтийн санаа бодолд нөлөөлөгчид.....	39
9. Зарим үр дүнгүүд хүйсээр	43
10. Дүгнэлт	49
Хавсралт.....	51

ЗУРАГ БОЛОН ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	Түүврийн хэмжээ	7
Зураг 3.1.	Манай улсад авлига түгээмэл үзэгдэл болсон	12
Зураг 3.2.	Сүүлийн гурван сард өрхүүдийн өгсөн хээл хахуулийн давтамж.....	12
Зураг 3.3.	Та дээд түвшний авлигын талаар хэр их олж сонсдог вэ? – (Байнга). Таны гэр бүл сүүлийн гурван сард хээл хахууль өгсөн үү? – (Тийм).....	13
Зураг 4.1.	2019 оны улс орны тулгамдсан асуудлууд.....	16
Зураг 4.2.	Авлигатай тэмцэхэд хүчин чармайлт гаргах удирдагчид (олон сонголттой асуулт 2006).....	17
Зураг 4.3.	Таны бодлоор авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (2019, нэг сонголттой асуулт)	17
Зураг 4.4.	Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ? (2007 болон 2019).....	18
Зураг 4.5.	Авлигатай тэмцэх газарт та хэр зэрэг итгэдэг вэ? 2019	19
Зураг 4.6.	Та Авлигатай тэмцэх газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддагт итгэдэг үү?	19
Зураг 5.1.	Дээд түвшиний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ?	22
Зураг 5.2	Цөөнгүй тооны улс төрчид авилгаас тодорхой ашиг хонжоо олдог учраас улс төрчдөд бодит хэрэг дээрээ авилгатай тэмцэх хүсэл эрмэлзэл байдаггүй	22
Зураг 5.3.	Авлигатай тэмцэх чиглэлээр Засгийн газрын амжилттай санаачилгууд	23
Зураг 5.4.	Авлигатай тэмцэх чиглэлээр Засгийн газрын үр ашиггүй байгаа санаачилгууд.....	24
Зураг 5.5.	Авлига нь том бизнесээс илүү жижиг, дунд бизнест сөрөг нөлөө үзүүлдэг.....	25
Зураг 5.6.	Одоогийн засгийн газар авлигатай тэмцэхэд өмнөх засагтайгаа харьцуулахад хэр сайн ажиллана гэж бодож байна?	26
Зураг 5.7.	Монголд олон нийтийн дунд нэр хүндтэй хүмүүсээс авлигатай хамгийн их тэмцдэг хүнийг та нэрлэнэ үү?.....	27
Зураг 7.1.	Авлигын талаарх голлох мэдээллээ Та аль эх сурвалжаас авдаг вэ?	34

Зураг 7.3.	Авлигын талаар мэдээлэл ил болгож дамжуулдаг телевизийн аль сувгийг та хамгийн их үздэг вэ? (Үндсэн гурван суваг, боловсролын түвшингөөр)	36
Зураг 8.1.	Монголд авлигын талаар хамгийн тууштай үзэл бодлоо илэрхийлж ил тод бичдэг сэтгүүлчийг та нэрлэнэ үү?	40
Зураг 8.2.	Монголд авлигын талаар хамгийн тууштай үзэл бодлоо илэрхийлж ил тод бичдэг сэтгүүлчийг та нэрлэнэ үү? (Хүйсээр)	41
Зураг 8.3.	Монголд авлигын талаар хамгийн тууштай үзэл бодлоо илэрхийлж ил тод бичдэг сэтгүүлчийг та нэрлэнэ үү? (Насны бүлгээр)	41
Зураг 8.4.	Монголд авлигын талаар хамгийн тууштай үзэл бодлоо илэрхийлж ил тод бичдэг сэтгүүлчийг та нэрлэнэ үү? (Боловсролын түвшингөөр)	42
Зураг 9.1.	Авлига манай улсад хэвийн үзэгдэл болсон	44
Зураг 9.2.	Авлига таны хувийн амьдралд хэр зэрэг нөлөөлдөг вэ?	45
Зураг 9.3.	Авлигад хамгийн их автсан салбаруудын үнэлгээ (дунджаар)	45
Зураг 9.4.	Таны бодлоор манай улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн хувьд өнөөдөр тулгамдаж буй хамгийн чухал асуудал юу вэ?	46
Зураг 9.5.	Таны бодлоор одоогийн Засгийн газар өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ?	47
Хүснэгт 5.1.	Улс төрчдийн рейтинг	27
Хүснэгт 6.1.	2019 оны 3 сарын төрийн байгууллагуудад итгэх итгэл	30
Хүснэгт 6.2.	Авлигад хамгийн их авсан 5 байгууллага	31
Хүснэгт 6.3.	Намуудын үнэлгээ	32
Хүснэгт А:	Түүврийн тархалт 2019	51

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

- ✔ 2019 онд судалгаанд оролцогчдын 93.6 хувь “авлига нь манай улсад хэвийн үзэгдэл болсон” гэдэгтэй санал нийлсэн нь 2018 оныхоос давсан үзүүлэлт боллоо.
- ✔ Гэсэн хэдий ч жижиг авлигын тохиолдлын буурах хандлага үргэлжилсээр 2019 онд 3-аас бага зэрэг илүү хувьтай байна.
- ✔ АТГ-т хандах сөрөг хандлага нэмэгдсээр байна. Энэ онд судалгаанд оролцогчдын 76.4 хувь нь АТГ-т итгэхгүй байгаагаа илэрхийлсэн бөгөөд дөнгөж 11.1 хувь нь уг байгууллагыг шударга гэж үзэж байна. Энэ хоёр тоон үзүүлэлт нь энэ асуултын бүх цаг үеийн хамгийн бага хувь юм.
- ✔ Олон нийт Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн засгийн газрын авлигатай тэмцэх чиглэлээр хийсэн ажлуудыг дэмжиж байгаа нь харагдлаа.
- ✔ 2019 он улс төрийн намууд болон шүүхийн тогтолцооны авлигын түвшингийн талаарх сөрөг хандлага нэмэгдэж байгааг харуулсан.
- ✔ Улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг доогуур үнэлэх хандлага хэвээр үргэлжилсэн бөгөөд 88 хувь нь улс төрчид асуудлыг шийдвэрлэх маш бага эсвэл огт хүсэлгүй байна гэж судалгаанд оролцогчид илэрхийлжээ.
- ✔ Цахим сүлжээний ач холбогдол тасралтгүй нэмэгдэж байгаа хэдий ч авлигын талаарх мэдээллийн хамгийн чухал эх сурвалж телевиз хэвээр байна.

ӨМНӨХ ҮГ

2019 оны SPEAK судалгаа нь Сант Марал Сан (СМС) болон Азийн Сангаас 14 жилийн хугацаанд явуулсан 19 дэх судалгаа билээ. Энэ жилийн судалгаа нь Канад улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр Азийн Сангаас хэрэгжүүлж буй “Ардчилсан Оролцоотойгоор төрийн албон сайн засаглал ил тод байдлыг бэхжүүлэх нь” (STEPS) төслийн хүрээнд явуулсан дөрөв дэх удаагийн судалгаа байв. Канад улсын Гадаад хэргийн яамны дэмжлэг энэхүү урт хугацааны судалгааг тасралтгүй явуулах, мэдээллийг хуримтлуулахад чухал үүрэгтэй байсан.

Энэхүү судалгааг авлигын цар хүрээ, олон нийтийн ойлголтыг илүү сайн тодорхойлох зорилгоор явуулж ирсэн. Олон жилийн туршид судалгаа нь авлигын чиг хандлагын талаар олон янзын ойлголтыг өгсөн. Мөн түүнчлэн Монгол улсын хөгжилд тулгарч буй энэхүү чухал сорилтын талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх мөн жил бүрийн авлигын талаарх мэдээлэлд суурилсан яриа хэлэлцээр өрнүүлэх чухал арга хэрэгсэл болсон.

Энэ жилийн тайлангийн хувьд СМС-ийн Гүйцэтгэх захирал Лувсандэндэвийн Сумати дахин ажилласан. Бид олон жилийн мэдээллээс ажиглагдаж буй чиг хандлагууд дээр тулгуурлан тайланд нэмэлт дүн шинжилгээ хийж, өөрсдийн санал дүгнэлтээ өгсөн бөгөөд санаа зовоож буй чиг хандлагыг өөрчлөхөд шаардлагатай зүйлүүдийн талаарх өөрсдийн саналыг санал болгож байна.

Монголчууд авлигад илүү их бухимдаж, эдгээр хор хөнөөлтэй үйлдлийн талаар улам мэддэг болсон нь эерэг зүйл юм. Гэсэн хэдий ч энэ жилийн судалгаанд авлигатай тэмцэх тогтолцооны байгууллагуудад итгэх итгэл, улс төрчдөөс хүлээх хүлээлт түүхэн доод хэмжээнд хүрч авлигын түвшин дахин шинэ дээд түвшинд хүрсэн байна. Судалгаа болон энэхүү тайлан нь Монгол улсад тулгарч буй сорилтыг даван туулахад туслах, мэдээллээр хангах зорилготой бөгөөд ирэх жилүүдэд эдгээр чиг хандлагыг өөрчлөхөд Монголчуудыг татан оролцуулах үр дүнтэй арга хэмжээнүүд авна гэдэгт бид чин сэтгэлээсээ найдаж байгаа.

Сонгуулийн бүх жилүүдийн нэгэн адил 2020 он Монголчууд сонголтоо хийхээр бэлтгэлээ базаах үед авлигын талаар яриа өрнүүлэх боломжийг олгож байна. Энэхүү тайлан нь тэдгээр хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулж, авлигын сэдэв болон энэ асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөөг мэтгэлцээний гол цэг болгоход тусална гэж найдаж байна.

Хүндэтгэсэн,



Марк Кэйниг

Азийн Сангийн Суурин Төлөөлөгч

1 СУДАЛГААНЫ ТУХАЙ



1. СУДАЛГААНЫ ТУХАЙ

2006 онд, Монголд анх удаа авлигын жишиг судалгааг явуулахаар Азийн Сан нь СМС-д авлигын талаар өргөн тархсан яриа өрнүүлэх зорилгоор суурь судалгаа хийх хүсэлт тавьсан. Үүний үр дүнд 2006 оны 3 сараас 2008 оны 9 сар хүртэлх хугацааны туршид явуулах зургаан удаагийн санал асуулгатай урт хугацааны судалгааны дизайныг боловсруулсан. СМС-ийн гүйцэтгэх захирал Л.Сумати Транспаренси Интернэшнл–Монгол байгууллагын захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байхдаа ил тод байдал, ардчилал, авлигын эсрэг хүчин чармайлтын асуудлаарх дэлхийн хэмжээний мэдлэг туршлагыг нэвтрүүлэх зорилгоор ТИ–Монгол байгууллагыг төсөлд оруулсан болно. Эхний гурван жилийн хугацаанд Британийн элчин сайдын яам уг төслийг санхүүгийн хувьд дэмжиж байсан. 2009 оны 3 сард төсөл дуусмагц СМС болон Азийн сан нь төслийг бие даан үргэлжлүүлэхээр шийдэж, өөрсдөө нэмэлт нэг удаагийн санал асуулга явуулсан. 2009 оны 9 сард АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн (USAID) дэмжлэгтэйгээр Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа (SPEAK) гэсэн нэрийн дор судалгааны цаг хүрээг өргөжүүлсэн. 2012 онд Азийн сан болон СМС нь Бизнес эрхлэлтийн орчин дахь Авлигын нөхцөл байдал судалгаа (STOPP)-г явуулж, тайланг гаргаж нийтэлсэн. 2015 онд Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг уг төслийг дэмжиж, 2016 оноос 2019 он хүртэл Канад улсын Гадаад Хэргийн Яам ивээн тэтгэсэн.

Судалгаа нь эхнээсээ үзэл баримтлалын түвшинд бэрхшээлтэй тулгарч байсан. Монгол хэл дээрх авлигын талаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт байхгүй байсан мөн одоо байгаа судалгаа нь барууны орнуудын соёл, эдийн засгийн үзэл баримтлалд тулгуурласан. Монгол Улс 1990 онд Зөвлөлт маягийн социалист системээс ардчилсан тогтолцоо руу шилжиж эхэлсэн. Арван зургаан жилийн дараа, 2006 онд эдгээр судалгаануудыг эхлэхэд, Монгол Улс өмнөх социалист үеэсээ олон шинж чанарыг өвлөн авсан төрийн (буюу олон нийтийн) болон хөгжиж буй бусад зах зээлтэй ижил олон онцлог шинж чанаруудыг агуулсан хувийн хэвшлийн холимог тогтолцоотой байсан. Энэ хугацаанд шударга ёсны хүрээнд соёлын өрсөлдөөн бий болж, ёс зүйд суурилсан Күнзийн хандлагаас Өрнөдөөс гарч ирсэн хууль дээдлэх үнэлэмжтэй өрсөлдөх үзэл санаа гарч ирэв. СМС нь энэхүү өрсөлдөөнийг 2001–2007 онуудад Монгол дахь хууль эрх зүйн шинэчлэлийг судалж үзэх үеэр дагаж Күнзийн үзэлд үндэслэсэн шүүхийн тогтолцооноос гадуур шийдэгдэх шүүхийн хэргүүд хурдацтай тэлж байгааг ажиглав¹.

2006 онд авлигын судалгааны баримтууд нь барууны авлигын үзэл баримтлал болох ТИ–ийн Дэлхийн Авлигын Барометр болон Авлигын Төсөөллийн Индекс (АТИ) дээр суурилсан байв. Тиймээс барууны аргачлалыг Монголд авлигын жишиг судалгааны үндэс болгон авсан. Аргачлал нь харьцуулсан судалгааны ажлыг эхлүүлэх боломжийг олгосон. Тухайлбал Зөвлөлт төв Ази, зүүн Европ зэрэг ижил шилжилтийн үетэй орнуудын судалгаа. Гэвч зарим дутагдалтай талуудтай байсан. Жишээлбэл, ТИ–ийн хамгийн сүүлийн үеийн авлигын тодорхойлолтод зөвхөн төрийн салбарын үйл ажиллагаа багтана:

“Ерөнхийд нь “хувийн ашиг олох зорилгоор итгэмжлэгдсэн эрх мэдлийг үрвүүлэн ашиглах”

1 “Сонгогчдын Дуу Хоолой II”, хуудас 156-158

гэж нэрлэдэг. Авлига нь алдагдсан мөнгөний хэмжээ болон салбараас хамаарч том, жижиг ба улс төрийн гэж ангилагдах боломжтой.

Их авлига нь төрийн өндөр түвшинд үйлдсэн хэргүүд байх бөгөөд бодлого, эсвэл төрийн үйл ажиллагааг гажуудуулж, удирдагчдад олон нийтийн зардлаар үр ашиг хүртэх боломжийг олгодог.

Жижиг авлига гэдэг нь бага, дунд шатны төрийн албан хаагчид өдөр бүр эмнэлэг, сургууль, цагдаагийн хэлтэс болон бусад агентлагууд гэх мэт газруудад бүтээгдэхүүн, үйлчилгээ авч байгаа иргэдтэй харилцахдаа эрх мэдлээ урвуулан ашиглахыг хэлнэ.

Улс төрийн авлига гэдэг нь албан тушаалаа урвуулан ашиглаж эрх мэдэл, албан тушаал, эд хөрөнгөө хадгалан үлдэх зорилгоор санхүүгийн эх үүсвэр хуваарилах болон санхүүжилт олгох бодлого, тогтолцоо, дэг журмыг залилан мэхлэх явдал юм”.

Бид судалгаандаа дээр дурдсан тодорхойлолтоос гадна хувийн хэвшлийн авлигын асуудалд онцгой анхаарал хандуулж байгаа. Төрийн салбараас бага хэдий ч хувийн хэвшлийн авлига нь хөгжиж буй эдийн засагт ихээхэн хор хөнөөл учруулдаг. Жишээлбэл, манай судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь Монголын болон гадаадын томоохон компаниудыг авлигын томоохон эх үүсвэр гэж үздэг. Бид өөрсдийн арга барилыг ялгаатай болгож авлигыг төрийн болон хувийн хэвшлийн аль аль салбарт хэмжих зорилгоор авлигын тодорхойлолтыг “өөрийн” биш “хувийн ашиг сонирхлын үүднээс итгэмжлэгдсэн эрх мэдлийг урвуулан ашиглах” гэж өөрчилсөн. Авлигын хэргүүд далд явагддаг учир түүнийг хэмжих нь маш төвөгтэй бөгөөд маргаантай байдаг. Ихэнхдээ тэдгээрийн зөвхөн цөөн хэсэг нь олон нийтэд ил болдог бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд авлигыг илчлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Судалгаандаа бид судалгаанд оролцогчдын өгсөн өрхийн статистик болон тэдгээрийн ойлголтыг нэгтгэсэн болно.

2006 онд монгол хэлэнд “авлига”-ын албан ёсны, түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолт байгаагүй. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг үг нь “авлигал” байсан бөгөөд монгол хэлээр авлига, хээл хахууль гэсэн утгаар ойлгож, хэрэглэгддэг. 2001 онд хэвлэгдсэн Монгол, Орос хэлний их эрдэм шинжилгээний толь бичигт “авлигал” нь авлигыг тодорхойлох “шинэ” нэр томъёо болж тэмдэглэгдсэн байна. Энэхүү нэр томъёог Монголын нийгэмд болж буй өөрчлөлт, түүний өөрчлөгдөж буй үнэт зүйлийг тусгах зорилгоор нэвтрүүлсэн. Хээл хахууль нь авлигын ердөө нэг хэлбэр учраас авлигын тухай ойлголт хэрхэн өөрчлөгдөж байгааг ажиглахын тулд судалгааны баг тусдаа бүлэг асуултуудыг судалгааны хэрэгсэлд оруулах шаардлагатай гэж үзсэн. Энэхүү нэмэлт асуулгын мөрийг авлигын эсрэг бодлогыг албан ёсоор боловсруулахад зааварчилгаа өгөх туслах хэрэгсэл болно гэж бид үзсэн. Гэсэн хэдий ч авлигын тодорхойлолтыг илүү боловсронгуй болгох үйл явц үргэлжилж байгаа бөгөөд судалгаа хийгдсэн олон жилүүдийн туршид олон нийтийн яриа хэлэлцээ, улс төрийн яриа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж буй мэдээлэлд энэхүү ойлголтын талаарх хандлага, үзэл бодол өөрчлөгдөж буйг тэмдэглэх нь зүйтэй. Жишээлбэл: сонгуулийн сурталчилгаанд бэлэг тараахыг хатуу хориглосон Сонгуулийн тухай хууль хэрэгжиж эхэлсний дараа бэлэг тараах үйл ажиллагааг авлигын тодорхойлолтоос гадуур гэж үздэг хүмүүсийн хандлага нэмэгдсэн.

Судалгааны загвар нь хоёр хэв шинжийг хамардаг: төрийн байгууллагын авлига болон хувийн

хэвшлийн авлига. 2012 онд судалгааны баг монголчуудад “Их Авлига” хэмээх цоо шинэ ойлголтыг танилцуулсан. “Их авлига” -г монгол хэлээр хэрхэн нэрлэх хоёр хувилбарыг авч үзсэн: барууны “grand corruption” гэсэн үгний орчуулга болох “их авлигал” гэх үү эсвэл Зөвлөлтийн орнуудад түгээмэл хэрэглэгддэг “high-ranking corruption” -ийг Оросын загварчлалаар “дээд түвшний авлига” гэж орчуулах. Бид Оросын хувилбарыг сонгосон боловч сүүлийн үеийн судалгааны үр дүнгээс харахад өндөр албан тушаалтнуудын авлигыг энэхүү хязгаарлагдмал хувилбараар оруулах нь буруу байсан гэж харуулсан. Сүүлийн үеийн тогтолцооны ёс зүйн гүнзгий хямрал, авлигыг илчилсэн улс төрийн үйл явдлууд мөн Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудал нь монголчуудын дунд олон нийтийн ашиг сонирхол зөрчигдөж байгаа талаарх болгоомжлол улам бүр нэмэгдэж байна. Улс төрд популист болон байгуулалтын эсрэг хөдөлгөөнүүд нь зөвхөн хувийн сонирхолтой хүчирхэг төрийн хүнд суртал, улс төрчдөд төдийгүй хувийн хэвшлийн томоохон болон олон улсын бизнест нөлөөлж байна. Үүнээс харахад Монголын олон нийт “Их авлига”-г төрийн өндөр албан тушаалтнуудын үйлдлээс давсан зүйл гэж хардаг нь ойлгомжтой.

Өнөөдрийг хүртэл явуулсан судалгаа нь Монгол дахь авлигын талаарх судалгаанд оруулсан хувь нэмэр төдийгүй эдгээр тулгамдсан асуудлын эргэн тойрны яриа хэлэлцээний идэвхтэй хэсэг юм. Тиймээс цаг хугацаа өнгөрөх тусам эдгээр ойлголтууд дээр үндэслэн хийгдсэн аливаа ажил болон боловсруулалт нь цаашдын мэдээлэл цуглуулах ажилд чухал үүрэг гүйцэтгэнэ.

2 ӨГӨГДӨЛ ЦУГЛУУЛАХ




2. ӨГӨГДӨЛ ЦУГЛУУЛАХ

Дээр судалгааны түүх хэсэгт дурдсанчлан SPEAK судалгаа нь Авлигын Үнэлгээний Анхны Судалгаа (АҮС) бөгөөд судалгааны ажлын хүрээнд 2006 оны 3 сараас 2019 оны 3 сар хооронд СМС-ийн судалгааны ажлын баг 19 удаагийн санал асуулга явуулж, 17 аймаг болон нийслэл Улаанбаатар хотод 20,022 оролцогчтой ярилцлага хийв. Хамгийн сүүлийн мэдээлэл цуглуулалт 2019 оны 3 сарын 14-ний өдөр эхэлж 2019 оны 4 сарын 15-нд дууссан. Эхний 18 судалгааны санал асуулгыг судлаач судалгаанд оролцогчтой ганцаарчилсан ярилцлага хийх замаар асуумжийг бөглөх арга (РАPI) ашиглан хийсэн бол 2019 онд Компьютерийн тусламжтайгаар (САPI) ярилцлага хийг аргыг нэвтрүүлсэн.

Авлигын талаар судалгаа хийх нь ямагт бэрхшээлтэй байсан боловч энэ жилийн судалгааны дүн Монголчуудын судалгаанд хамрагдах хүсэл эрмэлзэл эрс өөрчлөгдсөнийг харуулсан. СМС нь 2006 оноос хойш төрөл бүрийн судалгаа явуулж байсан хэдий ч АҮС нь Монголын хүн амын дунд хамгийн их таашаагдсан бөгөөд харьцангуй бага татгалзсан үзүүлэлттэй байв. Судалгаанд оролцогчид энэхүү асуудалд оролцохыг хүсч байсан бололтой. Мөн түүнчлэн судалгааны үр дүнг Азийн сан идэвхтэй түгээсэн явдал нь шаардлагатай хэвлэл мэдээллийнхний анхаарлыг судалгааны үр дүн дээр хандуулж чадсан байна. Энэхүү арга нь судалгаанд олон нийтийн сонирхлыг нэмэгдүүлж, санал асуулгад оролцогчдын татгалзах түвшинг бууруулж чадсан юм.

2019 онд СМС-ийг судалгааны баг авлигын талаарх олон нийтийн хандлагын тодорхой өөрчлөлтийг ажигласан. 2017-2019 оны хугацаанд авлигын тухай мэдээллийг маш ихээр дэлгэсэн нь хүн ам бүхимдалтай байгаагийн шинж юм. Энэ жилийн судалгааны ажлын үеэр татгалзсан хувь өндөр байсан. Авлигыг олон жилийн турш илчилсний дараа олон нийт авлигын эсрэг илүү их арга хэмжээ авахыг шаардаж байна.

Харьцуулалт хийх зорилгоор ихэнх асуултуудыг 2006 оноос хойш ижил хэвээр хадгалсан боловч олон жилийн туршид хурдацтай өөрчлөгдөж буй орчин болон шинээр гарч ирж буй сорилтууд нь судалгааны багийг шинэ асуудлуудыг нэвтрүүлэхэд хүргэсэн. Жишээлбэл, 2006 онд Авлигатай тэмцэх алба нь хараахан албажаагүй олон нийтээр хэлэлцүүлэх төсөл хэлбэртэй байсан бөгөөд АҮС-ийн санал асуулга нь оролцогчдын хүлээлтийг хэмжих зорилготой байсан. 2007 онд бие даасан Авлигатай Тэмцэх Газар (АТГ) байгуулагдсаны дараа АҮС түүнийг үнэлэх байдал руу шилжсэн. Түүврийн хэмжээг 2012 оноос эхлэн 1360 болгон нэмэгдүүлж 2019 он хүртэл тогтвортой байсан. Энэ жилийн хувьд санал бодлын зөрүүтэй байдлын талаар илүү их мэдээлэл танилцуулах зорилгоор хэвлэл мэдээллийн төрлүүд дээр үндэслэн түүврийн хэмжээг 1500 болгож нэмэгдүүлэв.

Зураг 2.1. Түүврийн хэмжээ

3 АВЛИГЫН ӨӨРЧЛӨЛТ



3. АВЛИГЫН ӨӨРЧЛӨЛТ

2006 оныг өнөөдөртэй харьцуулж үзвэл авилгын ерөнхий байдалд юу өөрчлөгдсөн бэ? Үүнд хариулахын тулд дор хаяж 15 жилийг эргэж харах шаардлагатай болно. Судалгааг эхлэхээс өмнө 2004 онд Монголын иргэний нийгмийн зарим төлөөлөгчид авлигын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрсөн. 2004 оны 8 сард тэд тус улсад авлигын асуудлаар онцгойлон ажиллах анхны байгууллага болох ТИ – Монгол хэсгийг байгуулсан. 2005 оны 2 сард ТИ-ийн дарга Питер Эйгений дэмжлэгтэйгээр эхний алхам болгон Монголын хэсэг авлигын удирдлагын түршлагаас суралцахаар Гүрж улс руу айлчлал зохион байгуулав.

Өнөөгийн Монгол улсын нөхцөл байдлыг ойлгохын тулд Гүрж, Монгол дахь төрийн эрх мэдэл бүхий элитүүдийн авлигыг шийдвэрлэх хоёр өөр хандлагыг харьцуулах нь зүйтэй юм. 2005 онд Гүрж улс авлигын эсрэг амжилттэй тэмцсэн түүхээрээ олон улсад танигдсан. Тухайн үед Монгол улсын авлигын түвшин ТИ- Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийн жагсаалтад дундуур байр эзэлдэг байсны хувьд дэлхийн хэмжээнд харьцангуй дундаж байв. Гэвч энэхүү дунд үнэлгээ нь голчлон авлигатай тэмцэх талаар юу ч хийдэггүй буюу ямарч өөрчлөлтгүйтэй холбоотой. Гүрж улсад авлигын эсрэг бодлогыг хоёр тулгуур дээр үндэслэн бий болгосон: нэг талаас Ерөнхийлөгч Саакашвилигийн удирддаг засгийн газрын элитүүдийн авлигыг арилгах хүчтэй хүсэл эрмэлзэл, нөгөө талаас засгийн газрын дэмжлэгтэй маш идэвхтэй ТББ-ын салбар болон маш олон идэвхтэй залуу сайн дурынхан². Гүрж улсын ТББ-ууд хөрөнгө, нөөцийн төлөө ширүүн тэмцэж байв. Түүнээс гадна мэргэжлийн салбаруудын холбоодынх нь зүгээс мөн тэмцэлүүд байсан. “Залуу эдийн засагчдын холбоо” нь бизнесийн байгууллагуудтай харилцаж, бизнесийн тогтворгүй нөхцөлийг өөрчлөхөд нь тусалсан. Тухайн үед “татварын систем” гэсэн шууд утсыг ажиллуулах нь тэдний гол төсөл байв. “Залуу хуульчдын холбоо” нь хууль эрхзүйн орчинд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан. Гишүүдийнхээ мэргэжлийн өндөр үр чадвараар үнэлэгдсэн “Залуу хуульч” холбоо нь хууль тогтоомж боловсруулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд УИХ-тай шууд хамтарч ажиллах байдлаар өөрсдийн мэдлэг түршлагаа хуваалцсан. “Эрх чөлөөний хүрээлэн” нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй харьцсан. Сэтгүүлчид нь “эрх чөлөөний хүрээлэн”-ийн үндэс суурь байсан тул тэд “нэг хэргийг илчлэх нь олон зуун ижил төстэй хэргийг шийдвэрлэхэд тусалдаг” зарчимд үндэслэсэн нэг хэргийг сонгон авч мэдээллэх аргад мэргэшсэн бөгөөд энэ нь нийгэмд ихээхэн нөлөө үзүүлсэн юм. “Эрх чөлөөний хүрээлэн” нь мөн Гүрж дэх иргэний нийгмийн үйл ажиллагааны төвлөрлийг тэнцвэржүүлэх зорилгоор Монголтой төстэй нийслэл болон хөдөө орон нутгийн сүлжээг бий болгохыг оролдсон.

Шударга сонгууль, Ардчиллын төлөөх олон улсын нийгэмлэг нь 1500 орчим сайн дурын ажилтнуудаас бүрдсэн өргөн сүлжээ бүхий байгууллага байв. Тухайн үед сайн дурын ажилтнуудын ихэнх нь байнгын ажил эрхэлдэг байсан бөгөөд удирдлага нь сайн дурын ажилчдад заримдаа нөхөн олговор өгдөг байсан. Олон нийт нь шударга, ил тод байдлыг хангах үүднээс сонгуулийн үйл явцыг хянах янз бүрийн хяналт мониторингийн үйл ажиллагаанд оролцдог байсан. Тиймээс бусад салбартай харьцуулахад улс төрийн үйл ажиллагааг хянах ажиллагаа нь маш олон тооны сайн дурын ажилчидтай байв. Үүний үр дүнд тэд олон улсын түвшинд сайн нэр хүндийг бий болгож чадсан. Олон янзын ТББ-ууд олон нийттэй

2 “ТИ – Хэрэг эрхлэх газар, Берлин болон ТИ-Гүржэд хийсэн айлчлалын тайлан”, ТИ-Монгол улсын гүйцэтгэх захирал Л.Сумати, 2005


шууд харилцаатай байх нь тэдний амжилтын түлхүүр байсан гэж мэдэгдсэн. Хэдийгээр эдгээр ТББ-ууд амжилттай байсан тэдний өмнө тулгардаг нийтлэг асуудал байсан нь дээд удирдлага нь байнга өөрчлөгдөх явдал байв, ялангуяа Ерөнхийлөгч Саакашвили ТББ-уудын удирдагчдыг засгийн газарт ажиллахыг ятгаснаас хойш. Энэхүү үйлдэл нь засгийн газрын авлигын эсрэг бодлогыг ахиулсан боловч ТББ-ын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн.

Монгол улс Гүржтэй адил шилжилтийн шатанд явж байсан орон байв. 2000 онд МАХН 1996 онд залуу ардчилагчдад алдаад байсан засгийн эрхээ буцааж авсан. 1996 онд МАХН одоогийхтой адил нам байгаагүй бөгөөд шинэ үеийн удирдагчидтай болсон байсан. Тэдний улс орон даяарх ялалт нь улс төрийн сөрөг хүчнийг бүрэн ялсан байсан тул МАХН УИХ, Ерөнхийлөгчийн тамгын газар, засгийн газрыг хяналтандаа авчээ. Үүний зэрэгцээ Монголын иргэний нийгмийн идэвх буурсан. Хэрэв 1990-ээд онд олон улсын өгөөмөр хандивлагчдын өгсөн асар их нөөц болон залуу идэвхтэнгүүд олон байсан бол 2000-аад оны үед тэднээс цөөн хэд л үлдсэн байв. Залуу үе өөр боломжийг хайж эхэлсэн: олон улсын байгууллага, бизнес эсвэл төрийн байгууллагад ажиллах болсон. Мөн засгийн газраас иргэний нийгмийг дэмжих, урамшуулахад анхаарал хандуулаагүйг хэлэх нь чухал юм. Цаг хугацаа өнгөрөх тутам засаглал дахь иргэний нийгмийн хяналт, шалгалт хязгаарлагдмал болж, улмаар Монгол улс засаглалын хувьд сул дорой байдалтай, энэ нөхцөл байдал нь засгийн эрх мэдэлд буй хүмүүс эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг нь улам бүр нэмэгдүүлсэн.


Мөн түүнчлэн, нэг намын засаглалын урт удаан уламжлал нь Монголын засаглалын хэв маягт муу өв үлдээсэн байв. Сонгуулийн мөчлөгөөс үл хамааран Монгол улс аливаа улс төрийн сөрөг хүчнийг арилгах гэсэн тасралтгүй оролдлогыг хийдэг. Улс төрийн эсэргүүцлээс зайлсхийхийн тулд томоохон эвсэл байгуулах нь үүнийг хэрэгжүүлэх ердийн стратеги болж байв. Ийнхүү 2004 онд сонгуулийн гэнэтийн үр дүн нь МАХН-ыг улс төрийн өрсөлдөгчидтэйгээ хамтарсан томоохон эвсэл байгуулахыг шахав. 2008 онд Ерөнхий сайд С.Баяр тэргүүтэй бас нэгэн “ердийн бус” томоохон эвсэл байгуулагдсан. Иргэний нийгэм сулхан байсан үед бизнес–улс төрийн нам хоорондын ашиг сонирхлын холбоо бий болж мөн олигарх бүлэглэлүүд олноор бий болсон нь 2004-2008 онуудад иргэний нийгмийн байгууллага эвсэл улс төрийн сөрөг хүчний дэмжлэгтэй хяналт, хариуцлагын хүчтэй механизмгүй Монголын улс төрд төвөгтэй чиглэлийг бий болгосон.

Дүгнээд хэлэхэд Гүржтэй харьцуулбал, 2006 онд Монгол улс хангалттай хүчтэй иргэний нийгэмгүй шинээр гарч ирж буй авлигын давалгааг сорих улс төрийн хүсэл зориг сул байв. Эдгээр чухал бүрэлдэхүүн хэсгүүдийн оролцоогүйгээр дэлхийн өнцөг булан бүрээс хийсэн ажиглалтаас харахад авлигын эсрэг бодлого хязгаарлагдмал нөлөөтэй байна. Тиймээс, 2005 онд улс орны хүнд нөхцөл байдал болон гадны тусламж хязгаарлагдмал байдлыг харгалзан ТИ–Монгол нь хоёр үе шаттай хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан. Үүнд эхний “үр хөврөлийн” буюу ажиглагчийн үе шат болон илүү таатай орчин бий болох хоёр дахь “хувьсан өөрчлөгдөх” үе шат орно. Энэхүү “үр хөврөлийн” үе шатанд Азийн сан нь Монголын хүн ам авлигын талаар ямар бодолтой байгаа, энэ чиглэлээр юу хийхээр төлөвлөж байгааг олж мэдэхийн тулд АҮС-г явуулах санааг боловсруулж дэвшүүлсэн болно.

Өнөө үед Монгол улс авлигатай тэмцэж “хувьсан өөрчлөгдөж” эхлэх дараагийн үе шатанд хэзээ хүрэхийг бид хэрхэн мэдэх вэ? Хүн ам нөхцөл байдлыг хэрхэн үнэлж байгааг Зураг 3.1 тодорхой харуулж байна. Сүүлийн 14 жилийн хугацаанд “авлига нь манай улсад түгээмэл үзэгдэл” болсон гэдэгтэй судалгаанд оролцогчдын үргэлж 80-аас илүү хувь санал нийлнэ гэж хариулж байсан бөгөөд 2019 онд энэ тоо хамгийн дээд цэг болох 93.6 хувьд хүрсэн.

Зураг 3.1. Манай улсад авлига түгээмэл үзэгдэл болсон


Өрхүүдээс авлигатай холбоотой хувийн түршлагын талаар цуглуулсан мэдээллээс харахад илүү өөдрөг үр дүнг харагдаж байна (Зураг 3.2). Сүүлийн 14 жилийн хугацаанд жижиг авлигын тохолдлын хувь буурсан дүр зураг тод харагдаж байна. Бүх оролцогчид судалгааны ажилтанд ийм төрлийн мэдээллийг ил гаргахад бэлэн биш байдаг тул бодит тохиолдлын тоо арай өндөр байх магадлалтай хэдий ч жил ирэх тутам ерөнхий бууралт ажиглагдаж байгааг энд онцлох нь зүйтэй. Өрхийн түвшний авлигын тоо, хэмжээ эрс буурсан харагдаж байгаа бөгөөд 2019 онд түүврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлсэн ч авлигын жижиг хэргүүдийг баталгаажуулахад тус болоогүй. Тиймээс 2019 оны судалгаа нь СМС-ийн жижиг авлигын талаарх тоон судалгааны эцсийн судалгаа гэж тэмдэглээд ирээдүйд түүний үр нөлөөг зөвхөн чанарын судалгаагаар үнэлэх нь зүйтэй. Үүний зэрэгцээ хувийн түршлагаараа дамжуулан авлигад өртсөн гэж мэдээлэх судалгаанд оролцогчдын тоо мэдэгдэхүйц буурч байгааг нэмж дурдах шаардлагатай.

Зураг 3.2. Сүүлийн гурван сард өрхүүдийн өгсөн хээл хахуулийн давтамж

Жижиг авлигын талаарх мэдээлэл дээр үндэслэн тодорхой зөрчилдөөн гарч байна. Жижиг авлига 28 хувиас 3 хувь болж буурсан байхад авлига нь “ердийн үзэгдэл болсон” гэдэгтэй санал нийлэх оролцогчдын тоо яагаад 93 хувьд хүрээд байна вэ? Зураг 3.3 нь таамаглалын тодорхой үндэслэлийг өгөх болно. Жижиг авлигын тохиолдлын хувь буурч байгаа хэдий ч их авлигын талаар сонсох давтамж ихсэж байгаа нь үүнээс харагдаж байна.

АҮС-ны оролцогчид их авлигын хэмжээ, нөлөөллийг хувийн туршлага гэхээсээ илүү хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан авсан мэдээллээр үнэлэх боломжтой болох нь тодорхой байна. Үүний үр дүнд сүүлийн үед их авлигын хэргүүдийг нийтэд дэлгэснээр тухайн асуудлын талаарх хүн амын мэдлэг дээшлэхэд нөлөөлж байна. Жишээлбэл, 2019 оны 6 сарын 14-ний өдрийн тогтмол хэвлэлийн мэдээллийг шинжлэхэд: а) “Өнөөдөр” сонинд - их авлигын талаар хоёр өгүүлэл; б) “Өдрийн сонин” -д - дөрвөн нийтлэл; в) “Зууны мэдээ” –д хоёр нийтлэл байна.

Зураг 3.3. Та дээд түвшний авлигын талаар хэр их олж сонсдог вэ? – (Байнга). Таны гэр бүл сүүлийн гурван сард хэзээ хахууль өгсөн үү? – (Тийм)



Харамсалтай нь Гүржийн жишээ хуулбарлахад хэцүү онцгой тохиолдол байгаа юм. Энэ нь М.Саакашвилигийн Украинд Гүрж маягийн авлигын эсрэг бодлогыг хэрэгжүүлэх гэж оролдсон амжилтгүй оролдлого нотлох бөгөөд эцэст нь бухимдсан Украины засгийн газар түүнтэй сөргөлдсөн.

Олон улсын мэдээнд өндөр түвшний авлигын тухай нийтлэл нэлээд түгээмэл байдаг. Унгар, Румын, Словак зэрэг посткоммунист Европын холбооны гишүүн орнууд авлигын талаар мэдээнд олонтаа гарч ирдэг. Гэвч эдгээр үйлдлийн цар хүрээ болон нөлөөллийг сайн ойлгоогүй байгаа. Жишээ нь: “Европын холбооны улс орнуудын авлигын өртөгтэй холбоотой хамгийн сүүлийн үеийн тооцоогоор жил бүр 179 тэрбумаас 950 тэрбум еврогийн ДНБ-ний алдагдлыг бий болгож байна”³ гэх ерөнхий тооцоолол байна. Энэхүү мэдэгдлийн өнгө аяс нь ЕХ-ны хэмжээнд ч авлигын бодит цар хүрээг хэн ч мэдэхгүй байгааг мөн хэн нэгэн мэдэхийг хүсч байгаа эсэх дээр эргэлзэж болохоор байна.

3 “Европын Холбооны хэмжээн дэх авлигын өртөг,” <https://www.greens-efa.eu/en/article/document/the-costs-of-corruption-across-the-european-union/>

Төв Азийн посткоммунист орнууд, түүний дотор Монгол улс авлигатай тэмцэхэд Зүүн Европын орнуудтай ижил төстэй бэрхшээл тулгарч байгаа бөгөөд нэмэлт саад тотгор ч байгаа. Нэгдүгээрт, тэд бүгдээрээ хэцүү шилжилтийг туулсан эсвэл одоо туулж байгаа. Хоёрдугаарт, авлигатай тэмцэх ёстой байгууллагууд уг асуудлыг шийдвэрлэхэд тааруухан байна. Гуравдугаарт, эдгээр улсуудын хүч чадал бүхий элитүүд улс төрийн эрх мэдэл болон хувийн баялагтай холбоотой хоёр шалтгаанаар нийгмийн баялгийн хуваарилалтад тавих хяналтаа сулруулах сонирхолгүй байгаа юм. Эцэст нь Төв Ази нь газарзүйн хувьд дэлхийн улс төрийн гол бодлогын хил хязгаар дээр оршдог бөгөөд тэд хүчирхэг хөршүүдийнхээ нөлөөнд өртөмтгий байдаг: Авлигын томоохон асуудалтай Орос болон Хятад улс.

Хэрэв бид Монголыг далд эдийн засгийн төстэй асуудалтай хөрш зэргэлдээ ОХУ-тай харьцуулбал байдал түгшүүртэй байна. Оросын нэрт социологич Игорь Чубайс⁴:

“...хууль бус экспорт төсөвт ноцтой хохирол учруулж байна ... тэрээр импорт, экспортын талаарх Улсын Гаалийн Газрын мэдээлэл, хиллэж байгаа улс орнуудын мэдээлэл болон ДХБ, НҮБ-ын мэдээллийн хоорондын зөрүү 30-70% хүрдэг. 2013 онд “саарал” импорт, экспортоос Оросын төсвийн гаалийн алдагдал дор хаяж 2.5 их наяд рубль⁵ байв. Өнгөрсөн жилийн⁶ улсын төсвийн орлогын нийт хэмжээ 19 их наяд рубль байсан гэдгийг санууль”.

Монголд импорт, экспортын залилангийн ижил төстэй хэргүүдийн талаар бид сонссон боловч хэн ч энэ талаар олон нийтэд нээлттэй мөрдөн байцаалт явуулаагүй байгаа. Зөвхөн ховор хэдэн тохиолдлууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр гардаг ч энэхүү хязгаарлагдмал мэдээлэл нь гаалийн газрыг авлигад хамгийн их автсан байгууллагуудын нэгээр нэрлэхэд судалгаанд оролцогчдод хангалттай байна.

4 <http://www.kasparov.ru/material.php?id=5C8A27711DBAC>, 2019 оны 3 сарын 14

5 Ойролцоогоор 34.2 тэрбум евро

6 2018 оныг дурдав

4 АВЛИГЫН ЭСРЭГ ТЭМЦЛИЙГ ХЭН УДИРДАН ЧИГЛҮҮЛЭХ ЁСТОЙ ВЭ?



4. АВЛИГЫН ЭСРЭГ ТЭМЦЛИЙГ ХЭН УДИРДАН ЧИГЛҮҮЛЭХ ЁСТОЙ ВЭ?

14 жилийн хугацаанд авлигын талаар судалгаа явуулахад оролцогчдын дунд тухайн сэдэвтэй холбоотой тодорхой бухимдал ажиглагдаж байна. Судалгаагаар авлига нь ихэвчлэн улс орны хамгийн чухал асуудлуудын дээгүүрт эрэмбэлэгддэг. 2019 онд 3-р эрэмбэлэгдсэн бөгөөд энэ нь 2017 болон 2019 оны туршид хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өндөр түвшний авлигыг ихээр дэлгэж байсантай холбоотой гэж үзэж болно.


Зураг 4.1. 2019 оны улс орны тулгамдсан асуудлууд



Монголын хүн ам авлигыг бидэнд тулгарч байгаа асуудлын дээгүүрт үнэлж байгаа ч биечлэн оролцож, шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэл сул байгаа нь харагдаж байна. Хэт их хувийн оролцоогүйгээр авлигыг шийдэж чадах шидэт сүм олох нь хамгийн сайн арга гэж үзэх хандлага түгээмэл байна. Олон нийтийн санаа бодлоор авлигын эсрэг мэргэшсэн байгууллага нь энэхүү шидэт сүм болох ёстой байв.

Авлигатай Тэмцэх Газар (АТГ) 2007 оны 1 сард байгуулагдсан. Өмнөх олон нийтийн хүлээлт, үүнээс авлигын эсрэг тэмцлийг хэн удирдан чиглүүлэх ёстой вэ гэдгийг харвал зарим нэг сонирхолтой зүйлс харагдана. Нэгдүгээрт, АТГ-аас авлигатай тэмцэхийн тулд юу хийх ёстой талаар тодорхой ойлголт олон нийтэд байгаагүй. Тийм ч учраас хэдийгээр засгийн газар сул талуудтай, бодлогын алдаа дутагдалтай байсан ч авлигатай тэмцэх ажлыг удирдан зохион байгуулах ёстой байгууллагуудын тэргүүнд нэрлэгдсэн (Зураг 4.2). Хоёрдугаарт, Тусгай Мөрдөн Байцаах Албаас өндөр хүлээлттэй байсан – ямар үүрэг гүйцэтгэхийг нь тодорхойлоогүй, хийсвэр гэж хэлж болохоор байгууллага байсан. Гурван дахь маш чухал зүйл бол авлигатай тэмцэх талаар ТББ-уудаас хүлээлт бага байсан явдал.

Зураг 4.2. Авлигатай тэмцэхэд хүчин чармайлт гаргах удирдагчид (олон сонголттой асуулт 2006)



2006 оноос 2019 онуудад хандлага хэрхэн өөрчлөгдсөн бэ? 2012 онд аргачлал өөрчлөгдсөний улмаас шууд харьцуулалт хийх боломжгүй ч хандлагын чиг өөрчлөлтийг ажиглаж болно. АТГ авлигатай тэмцэх байгууллагуудын дунд хүлээгдэж байсан тэргүүлэх байр суурийг эзэлсэн боловч 2006 онд ил тод байсан олон нийтийн дэмжлэгийг ихээхэн хэсгийг алдсан. АТГ өнөө үед иргэний нийгэм, ТББ-аас хэдийнээ доогуур байгаа хүлээлт эрс буурч байгаа нь сэтгэл түгшээсэн шинж тэмдэг юм. Иргэний нийгмийн идэвхтэй оролцоогүйгээр авлигатай тэмцэхэд ноцтой ахиц дэвшил гарах нь маш эргэлзээтэй хэдий ч ТББ-ын үүрэг олон нийтийн анхаарлын төвөөс бараг алга болжээ.

Зураг 4.3. Таны бодлоор авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ? (2019, нэг сонголттой асуулт)




АТГ-ын үйл ажиллагаа эхэлсэн эхний жилээс л нэг талаас олон нийтийн өндөр хүлээлт, нөгөө талаас бодит байдал хоёрын хооронд зөрүү гарч ирсэн. АТГ-ын гүйцэтгэлд өгөх сөрөг үнэлгээ тогтмол өсч байгаа нь АТГ институцийн хувьд удаан хугацаанд бэхжиж байгаатай холбоотой байж болох мөн АТГ-т итгэх итгэл унасаар байгаа нь гарч байгаа ноцтой авлигын асуудлууд, дээр нь шударга ёсны талаарх иргэдийн ойлголттой холбоотой байж болно.

2010 онд судалгаанд оролцогчдын дөнгөж 15.6 хувь нь АТГ-ыг шударга байгууллага гэж үзсэн. Харин манай улсын АТГ байгуулагдахад үлгэр дуурайл болж байсан Хонконг дахь Авлигын Эсрэг Комисс (ICAC)-ыг (АЭК) 1993 онд тухайн улсын иргэдийн 69.9 хувь анхнаасаа шударга⁷ гэж үзэж байсан байна. 2019 онд АТГ хамгийн муу үнэлгээ авсан бөгөөд оролцогчдын 76.4 хувь нь АТГ-ын шударга байдалд эргэлзсэн. Энэхүү үнэлгээ нь судалгаанд оролцогчдын шударга ёсны тухай ойголтоор АТГ-ыг бусад төрийн байгууллагуудтай ижил түвшинд аваачиж үзсэн бөгөөд АТГ-ыг авлигын эсрэг бие даасан байгууллага гэж үзэхгүй байгаа юм. 2014 онд АТГ нь олон нийтийн итгэлийг аажмаар нэмэгдүүлж, АТГ-ыг шударга гэж үзэх нь 24 хувьд хүрсэн боловч тэрхүү өндөр цэгээс хойш тасралтгүй уналт үргэлжилж байгааг 2019 оны үр дүнгээс мөн харж байна. Энэ жил тус байгууллага судалгаа явуулсан бүх жилийн хугацаанд бүртгэгдсэн хамгийн бага итгэлцлийн түвшин болох 11.1 хувьд хүрсэн байна.

Хонконгийн АЭК-ын талаарх олон нийтийн судалгааны зарим үр дүнтэй харьцуулж үзвэл, 2002 онд Хонконгийн АЭК олон нийтийн дунд нэр хүндээ хадгалаад зогсохгүй байр сууриа улам дээшлүүлснийг судалгаанд оролцогчдын 75.6 хувь түүнийг шударга байгууллага гэж үзсэнээс харж болно. Олон жилийн хугацаанд АЭК нь олон нийтийн дунд хүчтэй итгэлцлийг бий болгосон бөгөөд судалгаанд оролцогчдын 99 хувь нь түүнийг дэмжих нь зүйтэй гэж үзсэн байна. Монгол улсын нөхцөл байдлын тухайд 2010 онд судалгаанд оролцогчдын дөнгөж 41 хувь нь АТГ-т итгэж байсан бөгөөд энэ тоо 2019 онд 19 хувь болж буурсан. 2019 онд АТГ-т итгэх итгэл бүх цаг үеийн хамгийн бага түвшинд байгаа нь судалгаанд оролцогчдын 76.4 хувь түүнд итгэлгүй байгаагаа илэрхийлжээ.


Зураг 4.4. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ? (2007 болон 2019)




7 "Авлигыг хэмжих". Чарльз Сэмфорд, Артур Шаклок, Кармел Коннорс ба Фредрик Галтунг, х. 231

Зураг 4.5. Авлигатай тэмцэх газарт та хэр зэрэг итгэдэг вэ? 2019


a)



b)



Зураг 4.6. Та Авлигатай тэмцэх газар бие даасан, аль нэг улс төрийн хүчнээс хамааралгүй үйл ажиллагаа явуулж чаддагт итгэдэг үү?



Судалгаанд оролцогчдын дийлэнх нь АТГ-ыг улс төрийн хүчнээс хамааралтай гэж үзсэн.


5 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРЭГ




5. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРЭГ

Бид судалгаа явуулж эхэлсэн цагаас хойш засгийн газар болон АТГ нь авлигатай тэмцэх чиглэлээр тэргүүлэх байгууллагуудаар нэрлэгдэж ирсэн. АТГ авлигатай тэмцэх чиглэлээр тэргүүлэгч хэвээр байгаа боловч сүүлийн үеийн үр дүнгээс харахад олон нийт засгийн газрыг их авлигатай тэмцэхэд хамгийн гол үүрэгтэй байх ёстой гэж тодорхойлсон байна (Зураг 5.1). Хэдийгээр авлигатай тэмцэхэд засгийн газарт илүү найдлага тавьж байгаа боловч хэр ахиц гараж чадах талаар судалгаанд оролцогчид эргэлзээ өндөртэй байна (Зураг 5.2). Олон жилийн туршид энэхүү эргэлзээ улам бүр нэмэгдэж, 2017 оноос 2019 оны хооронд дээд цэгтээ хүрсэн бололтой, учир нь “улс төрчид авлигаас ашиг хүртэх боломжтой байдаг тул үүнтэй тэмцэх бодит хүсэл зориг байхгүй” гэсэн хандлагыг судалгаанд оролцогчдын 80 хувь нь их бага хэмжээгээр илэрхийлсэн байна. Нэмж дурдахад улс төрчид авлигыг арилгахад бэлэн эсэх талаарх асуултууд 2017-2019 онд хамгийн дээд утгатаа хүрсэн байна.

Зураг 5.1. Дээд түвшиний авлигатай тэмцэх ажлыг хэн/ямар байгууллага удирдан зохион байгуулах ёстой вэ?




Зураг 5.2 Цөөнгүй тооны улс төрчид авлигаас тодорхой ашиг хонжоо олдог учраас улс төрчдөд бодит хэрэг дээрээ авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл байдаггүй




Авлигатай тэмцэх чиглэлээр засгийн газрын гаргасан санаачилгуудын амжилт, бүтэлгүйтлийн үнэлгээ нь эргэлзээтэй байгааг харуулж байна. Засгийн газрын санаачлагуудын ололт амжилт одоогоор жижиг авлигыг бууруулснаар хязгаарлагдаж буй бололтой. Ийм амжилтуудын жишээ бол Нэг Цэгийн Үйлчилгээний төв зэрэг шинэ технологийг нэвтрүүлэх замаар ‘хүний хүчин зүйл’-ийн оролцоог хязгаарладаг эсвэл бууруулдаг төслүүд юм. Зураг 5.3-т бид зөвхөн: а) ач холбогдлын үнэлгээнээс “маш чухал”, болон б) хэрэгжүүлэх үр ашгийн үнэлэхээс “огт үр дүнгүй” гэсэн хоёр ангиллыг нэгтгэв. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр ач холбогдол нь нэмэгдэж байхад “огт үр дүнгүй” ангилал бараг үгүй болсон. Энэ нь санаачилга амжилттай хэрэгжиж байгаагийн тод илрэл юм.

Зураг 5.3. Авлигатай тэмцэх чиглэлээр Засгийн газрын амжилттай санаачилгууд

a)




b)




Гэвч өндөр түвшний авлигад чиглэсэн санаачлагуудын хувьд огт өөр дүр зураг харагдаж байна (Зураг 5.4). Оффшор мөнгийг Монгол руу буцаах оролдлогыг хүн ам үр дүнгүй гэж үнэлсэн (Зураг 5.4 с). Засгийн газар ил тод дансны бодлогод маш их хүчин чармайлт зарцуулсан боловч төслүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд мэдэгдэхүйц томоохон өөрчлөлт оруулах шаардлагатай байна (Зураг 5.4 б). Үүнтэй ижил нөхцөл байдал хөрөнгө орлогын мэдүүлгийн тайлан дээр ажиглагдаж байна. Тухайлбал 2019 онд судалгаанд оролцогчдын 52.9 хувь нь энэ төслийг “маш чухал” гэж үзсэн боловч 13.9 хувь нь үүнийг маш үр ашиггүй гэж үзсэн нь 2018 оныхоос мэдэгдэхүйц буурсан үзүүлэлт юм.

Зураг 5.4. Авлигатай тэмцэх чиглэлээр Засгийн газрын үр ашиггүй байгаа санаачилгууд


a)



b)




c)



2016 оны сонгуулиас хойш МАН-ын тэргүүлсэн хамтарсан засгийн газар авлигын цуврал дуулиан дэгдээгээд байна. Улс төрийн томилгоог зарахтай холбоотой “60 тэрбумын хэрэг” болон хэсэг УИХ-ын гишүүд, төрийн албан хаагчид Жижиг, Дунд бизнесийг хөгжүүлэх сангийн (ЖДҮ-н шуугиан) хөрөнгийг зүй бусаар ашигласан хэргүүд нь олон нийтийн дунд ихээхэн дургүйцлийг төрүүлсэн. Энэ нь мөн Засгийн газрын сайд нарын ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой шуугианыг өдөөсөн юм. Зураг 5.5-аас харахад Жижиг, Дунд бизнесийг дэмжих бодлогод аль хэдийн сөрөг байсан хандлага нь 2019 онд мэдэгдэхүйц өссөн байна. Судалгаанд оролцогчдын 96.2 хувь нь жижиг, дунд бизнес нь томоохон бизнесүүдийг бодвол авлигад илүү ихээр өртдөг буюу авлигын сөрөг нөлөөг илүү амсдаг гэж үзсэн байна.


Зураг 5.5. Авлига нь том бизнесээс илүү жижиг, дунд бизнест сөрөг нөлөө үзүүлдэг



Авлигын нөхцөл байдлын талаарх ерөнхий үнэлгээг үл харгалзан Ерөнхий сайд У. Хүрэлсүхийн засгийн газар авлигатай тэмцэх чиглэлээр хийсэн ажлынхаа үр дүнд олон нийтээс харьцангуй эерэг үнэлгээ авсан байна. 2019 оны 3 сард судалгаанд оролцогчдын 41.8 хувь нь өнөөгийн засгийн газар авлигатай тэмцэх ажлыг өмнөхөөсөө илүү сайн хийнэ гэж үзжээ (Зураг 5.6). Нэг жилийн өмнө энэ үзүүлэлт ердөө 15.8 хувь байсан.

Азийн Хөгжлийн Банк (АХБ) -аас гаргасан эдийн засгийн прогнозоос харахад 2016 оны сонгуулийн жил дэх 1.2 хувийн өсөлттэй харьцуулахад 2019 онд Монголын эдийн засагт 6.7 хувийн өсөлтийг тооцоолжээ. 2016 онд судалгаанд оролцогчдын дөнгөж 18.1 хувь амьдралынхаа түвшинг "сайн" гэж тодорхойлсон байсан бол 2019 онд энэ тоо нь шатахууны үнийн өсөлт, махны хомсдол болон ажилгүйдлийн өндөр түвшин зэрэг бэрхшээлүүдийг үл харгалзан 22.3 хувь⁸ болж өссөн байна. Үүний зэрэгцээ, СМС-гийн Политбарометр дахь засгийн газрыг ерөнхий үнэлгээ 2016 оны 6.2 хувиас 2019 онд 43.9 хувь болж өсчээ.

Зураг 5.6. Одоогийн засгийн газар авлигатай тэмцэхэд өмнөх засагтайгаа харьцуулахад хэр сайн ажиллана гэж бодож байна?



Эдийн засгийн эргээд өсөлттэй байгаа нь олон нийт Ерөнхий Сайд У. Хүрэлсүхийн засгийн газрыг дэмжиж буй цорын ганц хүчин зүйл биш юм. Тэрбээр бусад олон санал асуулгаар улс төрчдийн чансааны тэргүүн байранд бичигдэж байна. 2019 оны 3 сард гаргасан СМС-ийн ээлжит улс төрийн санал асуулгад үүнтэй ижил хандлага ажиглагдсан. SPEAK судалгаанд бид улс төрийн зэрэглэл тогтохоос зайлсхийдэг хэдий ч 2019 онд бид судалгаанд оролцогчдоос анх удаа: "Олны танил хүмүүсээс хэн нь Монголд авлигатай тэмцэх ажилд хамгийн их үүрэг гүйцэтгэсэн хүн бэ?" гэж асуусан (Зураг 5.7).

Улс төрийн янз бүрийн хямралыг бий болгосон институцийн бүтэц зохион байгуулалттай холбоотой хүндрэл бэрхшээл болон авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагааны үнэлгээ ерөнхийдөө буурч байгааг бид ажигласан бөгөөд олон нийтийн анхаарал, хүлээлт нь байгууллагуудаас хувь хүн рүү шилжиж байгаа харагдаж байна. Хувь хүмүүсийн зэрэглэлийг Хүснэгт 5.1-д үзүүлэв. Энэ нь 2019 оны SPEAK судалгаанд оролцогчдын тодорхойлсон авлигатай тэмцэх чиглэлээр амжилтанд хүрсэн шилдэг таван улс төрчдийг СМС-гийн Политбарометрийн 2019 оны чансаанд багтсан шилдэг таван улс төрчтэй харьцуулсан болно. Энэхүү хүснэгтийн бүтэц нь улс төрчдийн авлигатай тэмцэх байдал болон тэдгээрийн улс төрийн зэрэглэл хоорондын шууд хамаарлыг харуулж байна. Улс төрийн санал асуулгад дараах асуудлыг оруулсан: "Улс орны нэр хүндтэй хүмүүсийн дунд та улс төрд чухал үүрэг гүйцэтгэх ёстой хүмүүсийг хэн гэж нэрлэх вэ?". Энэхүү шууд хамаарал нь авлигатай тэмцэх ажлаараа танигдсан улс төрчид ихэвчлэн Монголын ард түмний дунд мөн алдагтай байх магадлалтайг харуулж байна.

Зураг 5.7. Монголд олон нийтийн дунд нэр хүндтэй хүмүүсээс авлигатай хамгийн их тэмцдэг хүнийг та нэрлэнэ үү?



Хүснэгт 5.1. Улс төрчдийн рейтинг

СМС-гийн Политбарометр 2019 “Улс орны нэр хүндтэй хүмүүсийн дотроос та улс төрд чухал үүрэг гүйцэтгэх ёстой хүмүүсийг хэн гэж нэрлэх вэ?”		SPEAK 2019 “Монголд олон нийтийн дунд нэр хүндтэй хүмүүсээс авлигатай хамгийн их тэмцдэг хүнийг нэрлэнэ үү?”	
1. Хүрэлсүх У.	24.3%	1. Оюун-Эрдэнэ Л.	15.9%
2. Баттулга Х.	21.5%	2. Хүрэлсүх У.	9.5%
3. Оюун-Эрдэнэ Л.	19%	3. Батзандан Ж.	8.5%
4. Батзандан Ж.	14.2%	4. Нямдорж Ц.	2.5%
5. Энхбаяр Н.	12.2%	5. Жавхлан С.	2.4%

Ихэнх тохиолдолд өндөр түвшний авлигын хэрэгт засгийн газрыг эхэлж буруутгана гэж бид боддог. Монгол улсын өнөөгийн нөхцөл байдалд засгийн газрын гурван сайд, түүний дотор Ерөнхий Сайд У. Хүрэлсүх авлигын эсрэг удирдагчдын чансааг тэргүүлж байна. 2019 оны хавар Ерөнхий Сайд У. Хүрэлсүх СМС-гийн Политбарометрийн дагуу улс төрийн хамгийн өндөр үнэлгээ авсан бөгөөд авлигатай тэмцэж буй улс төрчдийн чансааны хоёрдугаарт бичигдэж байна. Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын Дарга Л. Оюун-Эрдэнэ авлигатай тэмцэх чиглэлээр чансаагаараа тэргүүлж байна. Хууль Зүйн Сайд Ц. Нямдорж авлигын эсрэг улс төрчдийн жагсаалтын эхэнд мөн бичигдэж байгаа хэдий ч судалгаанд оролцогчдын цөөн хувь түүнийг шилдэг гуравтай⁹ харьцуулсан. Эрх баригч МАН-ын доторх тэмцэл нь намын нэр хүндийг доройтуулсан мэт санагдаж байгаа ч Ерөнхий Сайд энэхүү тэмцлээс түүнийг намын хуучны хамгаалагч гэж харсан бүтцийн эсрэг сонгогчдын улам их дэмжлэгийг авсаар гарсан бололтой. Гурав дахь зэрэглэлтэй улс төрч УИХ-ын гишүүн Ж.Батзандан Ерөнхий Сайд У.Хүрэлсүхийн засгийн газрыг дэмжиж намын захиалгын эсрэг санал хураалт явуулсны улмаар АН-ын гишүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш сөрөг хүчний томоохон нам болох АН-аас авлигын эсрэг чансааны тэргүүн байранд хэн ч орохгүй

9 Ц. Нямдорж сайд СМС-гийн Политбарометрийн шилдэг 10 улс төрчдийн жагсаалтад тогтмол багтдаг

нь гайхмаар. Судалгаанд оролцогчдын 47.8 хувь энэхүү асуултад хариулахдаа авлигыг бууруулах чиглэлээр үр дүнтэй ажилласан хэнийг ч нэрлэж чадахгүй байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Олон жилийн туршид ажиглагдсан олон нийтийн итгэл үнэмшил эрс буурсан ч улс төрийн намууд Монголын улс төрийн амьдралд хамгийн чухал үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд цаашид ч мөн гүйцэтгэх болно. Өнөөдөр авлигын асуудал улс төрийн хүчтэй хөдөлгөгч хүч болж гарч ирж байгаа бөгөөд энэ нь 2020 оны сонгуулиас өмнө шинээр гарч ирж буй “Үнэн ба Зөв” нам, “Шинэ Ардчилсан нам” зэрэг шинэ намуудын чухал тавцан болж байгаа юм.

6 БАЙГУУЛЛАГУУД



6. БАЙГУУЛЛАГУУД

Энэ тайлангийн 4-р бүлэгт бид иргэдийн авлигатай тэмцэх үүрэг бүхий үндсэн байгууллага болох АТГ-т ханддаг гутранги хандлагыг танилцуулсан. Монгол улсын бусад томоохон байгууллагуудын үнэлгээ үүнтэй ижил сөрөг хандлагатай байна. Төрийн байгууллагуудад итгэх итгэл бага байгаа нь тогтмол ажиглагдсаар байна. СМС-гийн Политбарометрийн судалгааны үр дүнгээс байгууллагуудад итгэх итгэлийн түвшинг харуулсан (Хүснэгт 6.1). Авлигатай тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэх ёстой гурван байгууллага буюу парламент, шүүхийн тогтолцоо болон улс төрийн намуудад итгэх олон нийтийн итгэлийн түвшин доогуур байна.

Хүснэгт 6.1. 2019 оны 3 сарын төрийн байгууллагуудад итгэх итгэл

	Ерөнхийлөгч	УИХ	Шүүхийн тогтолцоо	Төрийн захиргаа	Улс төрийн намууд	Иргэний нийгэм
их итгэдэг	33.8	6.8	11.9	17.7	2.9	18.0
итгэдэг	38.3	29.3	30.3	48.4	20.9	40.1
бараг итгэдэггүй	12.0	22.8	20.4	19.6	19.4	15.3
итгэдэггүй	13.0	39.8	35.3	13.9	54.3	20.3
(Харилтгүй)	0.0	0.0	0.0	0.0	0.1	0.0
(Мэдэхгүй)	3.0	1.3	2.0	0.4	2.3	6.3

АҮС–ийн урт хугацааны цугларсан мэдээлэл нь итгэлийн асуудлын цөмийг судлах сайн хэрэгсэл болдог. Хамгийн их авлигад өртсөн таван байгууллагын 2006-2008, 2017-2019 онуудын үнэлгээг харьцуулбал үр дүн нь асуудлын эх үүсвэрийг харуулж байна (Хүснэгт 6.2). Үнэлгээнд өөр өөр цаг үед хамрагдсан нийт байгууллагуудын тоо 20 орчим байгаа боловч ердөө тавыг нь тогтмол сонгож байсан. Итгэл найдвар бага байсан хоёр цаг хугацаанд шүүхийн тогтолцоо нь авлигад хамгийн их өртсөн байгууллагын тоонд орж байсан. 2019 онд шүүхийн тогтолцоо нь авлигад хамгийн их автсан байгууллагуудын хоёрт бичигдсэн. Үүнийг шүүх засаглалтай холбоотой авлигын хэргүүд гэнэт өссөнтэй холбож хэлэх нь хэцүү харин улс төрийн яриа, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд шүүх засаглалын салбарын авлигын асуудалд анхаарлаа хандуулсантай илүү холбоотой юм.

Хэрэв шүүх засаглал болон Газрын алба нь Монгол улсын авлигын асуудалтай байгууллагаар байнга нэрлэгдэж ирсэн бол сүүлийн үед гурван өөр этгээд (УИХ, улс төрийн намууд болон Засгийн газар) гарч ирсэн нь авлигын эсрэг үр дүнтэй бодлогыг боловсруулахад тулгарч буй хамгийн том саад бэрхшээлүүд болоод байна. Энэ асуудлаар 2019 оны судалгаагаар ажиглагдсан цорын ганц эерэг хандлага бол Засгийн газар авлигад өртсөн таван байгууллагын жагсаалтад багтаагүй явдал юм.

Хүснэгт 6.2. Авлигад хамгийн их авсан 5 байгууллага

	I	II	III	IV	V
3 сар 2019	Улс төрийн намууд	Шүүхийн тогтолцоо	Газрын алба	УИХ	Орон нутгийн худалдан авах тендер
3 сар 2018	Газрын Алба	Улс төрийн намууд	УИХ	Үндэсний засгийн газар	Шүүхийн тогтолцоо/ Уул уурхайн
3 сар 2017	Газрын Алба	Улс төрийн намууд	Уул уурхайн	УИХ / Хууль эрх зүй	Үндэсний засгийн газар
3 сар 2008	Газрын Алба	Уул уурхайн	Гааль	Бүртгэл, Зөвшөөрлийн Үйлчилгээ	Шүүхийн тогтолцоо
3 сар 2007	Газрын Алба	Гааль	Уул уурхайн	Шүүхийн тогтолцоо	Бүртгэл, Зөвшөөрлийн Үйлчилгээ
3 сар 2006	Газрын Алба	Гааль	Уул уурхайн	Шүүхийн тогтолцоо	Цагдаа

Олон жилийн туршид ажиглагддаг олон нийтийн итгэл ихээхэн буурсан ч улс төрийн намууд болон УИХ нь Монголын улс төрийн амьдралын чухал үүрэг гүйцэтгэгч хэвээр байна. Улс төрийн намуудад тулгарч буй бэрхшээлүүд зөвхөн Монголд тулгараад байгаа асуудал биш юм энэ нь дэлхийн олон ардчилсан орнуудад ажиглагддаг. Монголын улс төрийн намууд сонгуулийн үеэр авлигын талаар олон удаа амлалт өгдөг ч энэ нь ихэвчлэн тэдний сонгуулийн хөтөлбөрт бодитой болон тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөө болж ороогүй байдаг. Одоо 2019 онд авлигын сэдэв нь улс төрчдийн рейтингд хүчтэй хөдөлгөгч хүч болсонтой холбоотой улс төрийн намууд магадгүй 2020 оны сонгуулийнхаа бодлогыг боловсруулахдаа үүнд хариу өгөх байх.

Улс төрийн намуудыг авлигатай тэмцэх чадавхаар нь эрэмбэлж харах гэвэл санал асуулгаар авлигын эсрэг хатуу байр сууриа илэрхийлдэг нэр хүндтэй нам байхгүй байгаа нь хачирхалтай. Үндсэн хоёр нам хоорондоо маш төстэй түвшинд байгаа бөгөөд ялгаа нь алдааны магадлал доторх хэмжээний байна. Шинэ намууд олон нийтийн дэмжлэгийг илүү авч байна гэсэн маргаан гарч болзошгүй. Үүнд нь одоогийн дэмжлэгийн хувьд бусад хуучин жижиг улс төрийн намуудаас (Хүснэгт 3) давсан “Үнэн ба Зөв” (ҮБЗ нам 2017 онд бүртгэгдсэн) гэх мэт намууд багтдаг. Энэхүү нам нь бүтцийн байгуулалт болон авлигатай тэмцэх чиглэлд анхаарлаа төвлөрүүлдэг ч одоогоор SPEAK гэх мэт судалгаанд илүү хүчтэй орж ирэхээр харагдац бага байна.

2020 оны сонгууль ойртох тусам ҮБЗ намын авлигын болон бүтцийн байгуулалтын эсрэг сурталчилгаа бусад намуудад тархах төлөвтэй байна. Үүний тод жишээ бол саяхан судалгааны үеэр албан ёсоор бүртгэгдээгүй байсан “Шинэ нам” нэрээр АН-аас УИХ-ын гишүүн Лу. Болд, Батзандан нар салсан явдал

юм. Улс төрд хандах ийм хандлага сонгогчдод тодорхой байдлаар нөлөөлөх эсэхийг тодорхойлохын тулд илүү олон санал асуулга явуулах шаардлагатай болно.

Хүснэгт 6.3. Намуудын үнэлгээ

Улс Төрийн Барометр 2019 “Хэрэв УИХ-ын сонгууль маргааш болох байсан бол та аль намд саналаа өгөх вэ?”		SPEAK 2019 “Таны бодлоор авлигын эсрэг хүчтэй мөрийн хөтөлбөртэй улс төрийн нам байгаа юу?”	
1. Монгол Ардын Нам	14.7%	1. Ардчилсан нам	4.4%
2. Ардчилсан нам	11.4%	2. Монгол Ардын Нам	3.8%
3. МАХН	8.5%	3. Үнэн ба Зөв нам	2.1%
4. Үнэн ба Зөв нам	2.3%	4. МАХН	2.0%
5. Бүгд найрамдах нам	1.0%	5. Бүгд найрамдах нам	0.4%

7 МЭДЭЭЛЛИЙН СУВГУУД



7. МЭДЭЭЛЛИЙН СУВГУУД

Авлигын талаарх олон нийтийн хандлагыг судлахад авлигын хэргүүдийн талаар Монголын хүн амын хамгийн түгээмэл мэдээллийн эх сурвалжийн талаарх асуулт маш чухал юм. АТГ-ын үйл ажиллагааны үнэлгээг харуулсан Зурагт 4.4-т 2007 онд судалгаанд оролцогчдын 38.8 хувь “санал бодолгүй” байсан бол 2019 онд энэ хувь ердөө 4.5 хувь болж бүүрсан. Үүнтэй ижил байдал авлигын жижиг, дунд бизнест учруулсан хохирлын үнэлгээг харуулсан Зураг 5.5 харагдаж байна. 2006 онд судалгаанд оролцогчдын 10.7 хувь нь энэ сэдвээр санал бодлоо илэрхийлээгүй байсан бол 2019 онд 1.5 хувь нь илэрхийлээгүй байна. Жилийн туршид судалгааны хүрээнд асуугдсан хүн амын авлигын талаарх мэдлэг эрс сайжирсныг бид анзаарсан. Энэ нь судалгааны үр дүнд суурилсан мэдлэг мэдээллийг түгээдэг зорилго бүхий байгууллагуудын болон хэвлэл мэдээллийн олон нийтэд хандсан олон ажил, арга хэмжээний үр дүн байж болох бөгөөд илүү мэдээлжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийх нь чухал билээ.


2012 оны үеэр АҮС нь авлигын асуудлаар хүн амын мэдээллийн сувгуудыг шинжилж эхэлсэн (Зураг 7.1). Харьцангуй богино хугацаанд бид зарим томоохон өөрчлөлтийг ажигласан. Бага зэрэг хэлбэлзэлтэйгээр одоог хүртэл телевиз нь мэдээллийн гол эх үүсвэр хэвээр байна. 2019 онд судалгаанд оролцогчдын 71.3 хувь нь телевизийг авлигын талаарх мэдээллийн гол эх сурвалж гэж хариулсан. Цахим сүлжээ болон олон нийтийн сүлжээнүүд 2012 оны 3.8 хувиас 2019 онд 17.9 хувьд хүрч хамгийн их өсөлтийг харуулж байна. Үүний зэрэгцээ, “цуу яриа” мэтийн уламжлалт эх сурвалж 2012 оны 11.8 хувиас 2019 онд 4.6 хувь болж буурч байна.

Хоёр өөр буурч буй хандлагыг мөн анхаарах хэрэгтэй. Сонин, сэтгүүлүүд мэдээллийн гол эх үүсвэр байхаа больж үүрэг нь маш бага болжээ (Зураг 7.1б). Мөн хувийн туршлага нь мэдээллийн гол эх сурвалж биш болсон.


2019 онд судалгаанд оролцогчдын ердөө 1.3 хувь нь энэ сувгийг гол суваг гэж мэдээлсэн. “Хувийн туршлага” нь маш бага ач холбогдолтой байсан бөгөөд 2012 онд 3 хувь байснаас 2019 онд 1.7 хувь хүртэл буурсан. Энэ хандлага нь бидний ажигласан жижиг авлигын тохиолдлууд буурч байгаа статистикийн нотолгоо болж магадгүй юм.

Зураг 7.1. Авлигын талаарх голлох мэдээллээ Та аль эх сурвалжаас авдаг вэ?

а)




b)




Олон нийтэд мэдээлэл түгээхэд телевизийн үүрэг маш чухал хэдий ч телевизийн сувгуудын хооронд тодорхой ялгаа бий. Зарим телевик авлигын сэдэвтэй төдийлөн холбогддоггүй байхад зарим нь тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Судалгаанд оролцогчдын тайланд ТВ9 болон МҮОНР гэсэн хоёр суваг хэвлэл мэдээллийн чиглэлээр давамгайлж байна. Нийлээд энэхүү хоёр сувгийг судалгаанд оролцогчдын 68 орчим хувь нь “хамгийн их үзсэн” гэж мэдээлсэн байна (Зураг 7.2). ТВ9 нь нийт оролцогчдын 38.7 хувьтайгаар тэргүүлэх байр суурь эзэлдэг. Судалгаанд оролцогчдын боловсролыг телевизийн сувгийн сонголттой харьцуулсан хүснэгт нь ТВ9-ийн үзэгчид дунд өндөр боловсролтой судалгаанд оролцогчдын хувь бага байгааг харуулж байна. Боловсролын түвшин өндөртэй судалгаанд оролцогчид бусад сувгуудын хооронд жигд хуваарилагдсан байна (Зураг 7.3).

Зураг 7.2. Авлигын талаар мэдээлэл ил болгож дамжуулдаг телевизийн аль сувгийг та хамгийн их үздэг вэ?




Зураг 7.3. Авлигын талаар мэдээлэл ил болгож дамжуулдаг телевизийн аль сувгийг та хамгийн их үздэг вэ? (Үндсэн гурван суваг, боловсролын түвшингөөр)





Авлигын асуудлаар хамгийн мэдээлэлтэй сувгаар судалгаанд оролцогчдын 40 гаруй хувь нь ТВ9-ийг тодорхойлжээ (Зураг 7.4). Нэмж дурдахад хамгийн их үзэгчтэй TV9 суваг нь Монгол улсад авлигыг ил болгоход нөлөө бүхий томоохон хэрэгсэл болжээ.

Зураг 7.4. Авлигын талаар хамгийн их мэдээлдэг телевизийн сувгийг нэрлэнэ үү?




Сонин, сэтгүүлүүд нь жижиг боловч ач холбогдолтой үзэгчдийг хамардаг. Энэхүү хэсгийг судалгаанд оролцогчдын 6.7 хувиар “Өдрийн сонин” тэргүүлж байна (Зураг 7.5). “Ноцтой мэдээ” болон “Зууны мэдээ” тус бүр 2.7 хувьтай байна. “Өдрийн сонин” хамгийн мэдээлэл сайтай байдлаар тэргүүлж (Зураг 7.6), мэдээлэл сайтай эх сурвалжийн хоёрдугаарт “Өнөөдөр” оржээ.


Зураг 7.5. Авлигын талаар мэдээлэл ил болгож бичдэг аль сонин, хэвлэлийг та хамгийн их уншдаг вэ?**Зураг 7.6.** Авлигын талаар хамгийн их мэдээлдэг сонин, хэвлэлийг нэрлэнэ үү?

Мэдээллийн цахим хуудсуудын хувьд тархац нь телевиз, сониноос хамаагүй өргөн байгаа. Уншигчдаараа тэргүүлэх гурван вэбсайт бол gogo.mn, medee.mn болон news.ms сайтууд юм. Мэдээллээр хангах тал дээр ижил гурван вэбсайт өөр дарааллаар үнэлгээнд гарч ирсэн: medee.mn, news.mn болон gogo.mn.

Зураг 7.7. Авлигын талаар мэдээлэл ил болгож тавьдаг аль интернет/цахим хуудсыг та хамгийн их уншдаг вэ?



Зураг 7.8. Авлигын талаар хамгийн их мэдээлдэг интернет/цахим хуудсыг нэрлэнэ үү?



8 ОЛОН НИЙТИЙН САНАА БОДОЛД НӨЛӨӨЛӨГЧИД




8. ОЛОН НИЙТИЙН САНАА БОДОЛД НӨЛӨӨЛӨГЧИД

Авлигатай тэмцдэг хэвлэл мэдээллийн эсвэл олон нийтийн манлайлагчдын талаарх асуултад судалгаанд оролцогчид өөрсдийн хүссэн нэрээ өгч болохоор нээлттэй байдлаар асуусан. Мэдээлэл цуглуулах ажил дууссаны дараа нийт 48 сэтгүүлчийн нэр бүхий мэдээллийн багцыг хүлээж авсан. Судалгаанд оролцогчдын бараг тэн хагас нь (48.2 хувь) ямар ч нэр зааж өгч чадаагүй. Энэ үр дүн нь хамгийн алдартай олон нийтийн зүтгэлтнүүдийг сонгохтой төстэй (Зураг 5.2) бөгөөд судалгаанд оролцогчдын 47.8 хувь нь хэнийг ч нэрлэж чадаагүй бол үлдсэн 52.2 хувь нь нийлээд 67 хүнийг нэрлэсэн.

Авлигатай тэмцэхэд хувь хүний үүрэг нэмэгдэж байгаа нь улс төрд төдийгүй хэвлэл мэдээллийн орон зайд ажиглагдаж байна. TV9 болон МҮОНТ сувгууд нь телевизийн нэвтрүүлгийн тод манлайлагчид бол хатагтай Л. Мөнхбаясгалан, ноён М. Батбилэг нар хэвлэл мэдээллийн салбарын нөлөөлөгчдийн тоонд багтдаг (Зураг 8.1). Л. Мөнхбаясгалан бол С1 суваг дээр гарч буй “Цензургүй яриа” нэвтрүүлгийн зохиогч, харин М. Батбилэг TV9 телевизийн “Монгол коммент” нэвтрүүлэгт оролцдог. Судалгааны тавны нэгээс яльгүй илүү (21.3 хувь) оролцогчид хатагтай М. Мөнхбаясгаланг “Монгол улсад авлигын хэргийг ил болгоход хамгийн их үр дүнтэй” байсан гэж үзсэн бөгөөд тавны нэг (19.7 хувь) нь ноён Батбилэгийг нэрлэжээ.


Зураг 8.1. Монголд авлигын талаар хамгийн түүштай үзэл бодлоо илэрхийлж ил тод бичдэг сэтгүүлчийг та нэрлэнэ үү?




Нийгмийн бүлгийн тухайд хатагтай М. Мөнхбаясгаланг эрчүүд илүүтэй үзэх дуртай байдаг (Зураг 8.2) бол ноён Батбилэг залуу үеийнхнээс илүү дэмжлэгтэй байна (Зураг 8.3). Хатагтай Мөнхбаясгалангийн дэмжигчдийн дунд өндөр боловсролтой хүмүүсийн эзлэх хувь багагүй байна (Зураг 8.4).

Монголын цахим блогийн салбар нь өөрийн удирдагчид гарч ирэхийг хүлээсээр байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь (94.1 хувь) ямар ч блогерын нэрийг хэлж мэдэхгүй байв. Үлдсэн 6 хувийн хариултыг судалж үзэхэд тэдний ихэнх нь асуултыг бүрэн ойлгоогүй бөгөөд хариулт нь хамааралгүй гэж бид ойлгосон.


Зураг 8.2. Монголд авлигын талаар хамгийн түүштай үзэл бодлоо илэрхийлж ил тод бичдэг сэтгүүлчийг та нэрлэнэ үү? (Хүйсээр)



Зураг 8.3. Монголд авлигын талаар хамгийн түүштай үзэл бодлоо илэрхийлж ил тод бичдэг сэтгүүлчийг та нэрлэнэ үү? (Насны бүлгээр)



Зураг 8.4. Монголд авлигын талаар хамгийн түүштай үзэл бодлоо илэрхийлж ил тод бичдэг сэтгүүлчийг та нэрлэнэ үү? (Боловсролын түвшингөөр)



9 ЗАРИМ ҮР ДҮНГҮҮД ХҮЙСЭЭР



9. ЗАРИМ ҮР ДҮНГҮҮД ХҮЙСЭЭР


Өмнөх жилүүдийн нэгэн адил 2019 онд авлигад хандах хандлагад хүйсийн ялгаа бага байсан, тухайлбал эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоёулаа авлигыг улс орны нийтлэг үзэгдэл гэж үнэлсэн (Зураг 9.1 харна). Гэхдээ хүйсийн хуваагдмал хүснэгтүүдийн зарим нь онцлох хүйсийн ялгааг харуулж байна. Тухайлбал засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээ, мөн хээл хахууль өгснөөр өрхийн эдийн засагт учирч байгаа хохирлыг үнэлгээ зэрэг нь хүйсээр харьцуулж харвал ялгаатай үзэл бодол харагдаж байгаа юм.

Зураг 9.1. Авлига манай улсад хэвийн үзэгдэл болсон




Энэхүү ялгаанд нөлөөлж болох олон хүчин зүйлүүд байгаа. Нэг хүчин зүйл нь боловсролын түвшин байж болох юм. Дунджаар монгол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өндөр боловсрол эзэмших магадлал өндөр байдаг. 2015 оны Дэлхийн Эдийн Засгийн Форумын мэдээллээр Монголын их, дээд сургуульд хамрагдагсдын хүйсийн эмэгтэй эрэгтэй харьцаа 1.42 байсан. Манай 2019 оны судалгаагаар энэ харьцаа ижил байна: 1.41 (эмэгтэйчүүд 40 хувь, эрэгтэйчүүд 28.3 хувь). Эдгээр ялгаанд нөлөөлж буй өөр нэг хүчин зүйл нь өрхийн хөдөлмөрийн хуваагдал буюу эмэгтэйчүүд өрхийн санхүү болон сургуулийн бүртгэл, засгийн газарт бичиг баримт бүрдүүлэх зэрэг захиргааны ажлуудыг бүрэн хариуцаж байдаг байж болох юм. Үүнийг дагаад хээл хахуулийн улмаас гэр бүлийн төсөвт учирсан хохирлын тэдний үнэлгээ илүү оновчтой байх магадлалтай. Энэ нь мөн доорх Зураг 9.2 харуулснаар эмэгтэйчүүд авлигыг хувийн амьдралд нөлөөлдөг гэж илүү үзэх магадлалтайг тайлбарлана.

Зураг 9.2. Авлига таны хувийн амьдралд хэр зэрэг нөлөөлдөг вэ?



Хүйсийн ялгааны талаар хэдэн ажиглалт хийж болно. Өгөгдлийг үнэлгээнд 2-3 хувийн зөрүү нь статистикийн алдааны магадлал дотор байгааг санах хэрэгтэй. Түүнчлэн, эмэгтэйчүүд ерөнхийдөө аливаа сэдвийг сайн мэддэггүй гэдгээ хүлээн зөвшөөрөхдөө илүү нээлттэй байдаг. Зарим үндсэн ялгаа нь эрэгтэйчүүд илүү улс төрийг “их хэмжээгээр” авлигад автсан гэж үздэг. Энэхүү ялгаа нь мөн авлигад хамгийн их автсан салбарын үнэлгээнд эмэгтэйчүүд улс төрийн намуудыг шүүх засаглалын дараа хоёр дахь авлигад хамгийн их өртсөн салбарын ангилалд оруулах байдлаар харагдаж байна (Зураг 9.3).

Зураг 9.3. Авлигад хамгийн их автсан салбаруудын үнэлгээ (дунджаар).



Авлига гэж ямар зан авиртай болохыг ойлгохын тулд ялимгүй ялгаа ажиглагдаж байна. Үүнд эрчүүд илүү "төрийн албан тушаалыг ашиглан бэлэг, мөнгө авах"-ыг авлига гэж "их хэмжээнд" үздэг мөн илүү эрэгтэй судалгаанд оролцогчид улс төрийн намын үйл ажиллагааны хувийн санхүүжилтийг "их хэмжээнд" авлига гэж үздэг.


Улс орны өмнө тулгараад байгаа илүү чухал асуудлуудыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс хэрхэн үнэлдэг байдал ихээхэн ялгаатай байна. Судалгаанд оролцогч эмэгтэйчүүд амьдралын түвшинтэй холбоотой ажилгүйдэл, ядуурал болон буурч буй амьдралын түвшин гэх мэт асуудалд илүү анхаарлаа хандуулж байв (Зураг 9.4). Үүнтэй харьцуулахад эрчүүд чухал асуудлын хувьд авилгад илүү их анхаардаг.

Зураг 9.4. Таны бодлоор манай улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн хувьд өнөөдөр тулгамдаж буй хамгийн чухал асуудал юу вэ?



Эцэст нь эмэгтэйчүүд одоогийн засгийн газрын авлигатай тэмцэх үйл ажиллагааг үнэлэхдээ эрэгтэйчүүдээс илүү эргэлзээтэй ханддаг (Зураг 9.5).

Зураг 9.5. Таны бодлоор одоогийн Засгийн газар өмнөх Засгийн газартай харьцуулахад авлигын асуудлыг хэр шийдэж байна вэ?



10 ДҮГНЭЛТ



10. ДУГНЭЛТ

2006 оноос 2019 оны хооронд 14 жилийн хугацаанд Азийн Сан Сант Марал Сантай хамтран авлигын талаарх олон нийтийн ойлголт, Монгол дахь авлигын эсрэг тэмцлийн талаарх ойлголтыг өгсөн. Энэ хооронд авлига нь хээл хахууль хэлбэрээр илэрдэг дунд түвшнээс өндөр түвшний авлигын тогтолцоо руу шилжсэн. Хээл хахууль хурдан буурахын хэрээр их авлига газар авсан. Энэ нөхцөл байдалд 2007 онд авлигатай тэмцэх зорилгоор байгуулагдсан АТГ одоогоор 2019 онд олон нийтийн хүлээлтийг хангах боломжгүй байна. Монголын улс төрчид энэ асуудлыг шийдэх хандлагаа үндсээр нь өөрчлөх хүсэл эрмэлзэл байхгүйгээс тухайн байдал үүдэлтэй юм. Энэ нь засгийн газар солигдох бүрт мөн нэг сонгуулийн үеэс нөгөөд шилжих хүртэл асуудал хэвээр байна. Түүнээс гадна Монголын иргэний нийгэм нөхцөл байдлыг сорих хангалтай хүчтэй болон идэвхтэй биш байна. Одоогийн байдлаар хэвлэл мэдээллийн тавцан нь байгууллагууд биш хувь хүмүүсийн авлигатай тэмцэж, эерэг үр дүнд хүрч байгаа цорын ганц хэрэгсэл байна.

2018–с 2019 оны хоорондох ард иргэдийн бизнес–улс төрийн бүтцийн тогтолцоонд бухимдах байдал шинэ түвшинд хүрч улс төрийн эрчимтэй тэмцлийн асуудал болсон энэхүү хугацаа онцгой чухал байсан санагдаж байна. Ерөнхий сайд У. Хүрэлсүх ба түүний багийн авлигын эсрэг байр суурь нь монголчуудаас сайшаал авсан хэдий ч одоогийн дэмжлэгийн түвшин нь 2020 оны сонгуульд чухал хүчин зүйл болох нэмэлт тодорхой арга хэмжээ авах хүлээлтийг дагуулах ёстой. Авлигын болон бүтэц тогтолцооны эсрэг хөтөлбөр нь удахгүй болох сонгуульд нөлөө бүхий хүчин зүйл болох бөгөөд авлигын болон бүтэц тогтолцооны эсрэг бодлогын мөрийн хөтөлбөртэй гарч ирж байгаа шинэ намуудад ажиглагдаж байна. Хэрэв авлигын эсрэг стратегиуд 2020 оны сонгуульд чухал хүчин зүйл болж чадвал энэ нь өмнөх кампанит ажлаас эрс өөр байх болно. Авлигатай тэмцэх улс төрийн хүчин нэмэгдэх боломж байгаа ч сул дорой, бүхнээс хасагдсан иргэний нийгэм нь авлигатай үнэн бодитойгоор тэмцэж тогтолцооны өнгөц сайжруулалтаас илүү гарахад улам бүр төвөг учруулна.

ХАВСРАЛТ

Энэхүү тайланд 2019 оны 3 сарын 14-ний өдөр эхэлж, 2019 оны 4 сарын 15-нд дууссан SPEAK судалгааны үр дүнг онцолсон болно. Тоологчид нийслэл Улаанбаатар хотын найман дүүрэг, долоон аймгийн 22 суманд байрлах 1500 өрхөөс бүрдсэн 150 АШТН-тай ярилцлага хийсэн. Түүврийн тархалтыг дараах хүснэгтэд харуулав:

Хүснэгт А: Түүврийн тархалт 2019

Бүс нутаг	Хот/Аймаг	Дүүрэг /сум	Ярилцлага
	Улаанбаатар	Улаанбаатар	690
		Хан-Уул	80
		Баянзүрх	170
		Сүхбаатар	60
		Чингэлтэй	80
		Баянгол	110
		Сонгинохайрхан	160
		Налайх	20
		Багануур	10
	Аймаг		810
Баруун	Говь-Алтай		90
		Есөнбулаг (аймгийн төв)	40
		Баян-Уул	30
		Тайшир	20
	Завхан		100
		Улиастай (аймгийн төв)	40
		Идэр	30
		Цагаанчулуут	30
Хангай	Архангай		160
		Эрдэнэбулган (аймгийн төв)	50
		Өндөр-Улаан	40
		Эрдэнэмандал	40
		Чулуут	30

Бүс нутаг	Хот/Аймаг	Дүүрэг /сум	Ярилцлага
	Булган		120
		Булган (аймгийн төв)	40
		Дашинчилэн	40
		Хангал	40
Төв	Дорноговь		80
		Сайншанд (аймгийн төв)	60
		Иххэт	20
	Сэлэнгэ		160
		Сүхбаатар (аймгийн төв)	59
		Мандал	41
		Ерөө	30
		Сайхан	30
Зүүн	Дорнод		100
		Хэрлэн (аймгийн төв)	40
		Баян-Уул	30
		Цагаан-Овоо	30
	Нийт		1500

